

ЦЭРГИЙНХЭН ТӨРИЙН ОДОН, МЕДАЛИАР ШАГНАГДЛАА

Бичсэн Administrator

2015 оны 7-р сарын 10, Баасан гариг, 01:46 -

Монгол Улсын Ерөнхийлогчийн 2015 оны 7 дугаар сарын 6-ны одрийн 112 дугаар зарлигаар Ардын хувьсгалын 94 жилийн ой, Үндэсний их баяр наадмыг тохиолдуулан эрхэлсэн ажилдаа ондор амжилт, идэвх зүтгэл гарган ажиллаж байгаа зарим генерал, офицер, ахлагч, ажилтан албан хаагчдыг Монгол Улсын торийн одон, медалиар шагналаа. Шагналыг УИХ, Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Ц.Цолмон, ЗХЖШ-ын дарга, хошууч генерал Д.Даваа, БХЯ-ны Торийн нарийн бичгийн дарга, хошууч генерал З.Болдбаатар нар энэ сарын 8-ны одор гардуулав. Ходолморийн гавьяаны улаан тугийн одонгоор БХИС-ийн захирал, хошууч генерал Я.Чойжамц, Цэргийн гавьяаны Улаан тугийн одонгоор Зэвсэгт хвчний 123 дугаар ангийн захирагч, хурандаа Ц.Галбадрах, бэлтгэл хурандаа Я.Даваасамбуу, С.Энхтайван нарын, Цэргийн гавьяаны одонгоор БХЯ-ны ТЗУГ-ын Санхvv, эдийн засгийн хэлтсийн дарга, дэд хурандаа Д.Ганхуяг, ЗХЖШ-ын АУГ-ын ИЦХХ-ийн дарга, хурандаа Ц.Батсайхан, ЗХЖШ-ын ЦХҮГ-ын Хvн эмнэлгийн хэлтсийн дарга, дэд хурандаа С.Ганчимэг нарын олон офицер, ахлагч энгэрээ мялаалаа. Мөн Алтан гадас одон, Ходолморийн хvндэт медалиар цоонгvй хvнийг шагнаж урамшуулсан юм.